БАТЛАВ:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

2025 оны 04 сарын 11-ны өдөр

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН ХАНГИ ХИЛИЙН БООМТЫН УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОГТООХ ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЭРЭЛ-ХАЙГУУЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Судалгааны үе шат:	Газрын доорх усны эрэл-хайгуулын ажил
Судалгаа явуулах хугацаа:	Шалгарч гэрээ байгуулснаас хойш 5 сарын дотор /Үр дүнгийн тайланг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгнө/
Судалгааны талбайн нэр:	Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын суурьшлийн бүсээс 15-20 км радиуст, шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр талбайг өөрчлөх боломжтой. 42°43'6.57" 109°48'44.6", 42°45'45.58" 109°58'39.88", 42°49'24.44" 109°54'54.30", 42°46'54.99" 109°46'23.82", Нийт – 10,693 га талбайд
Хуудас:	4
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
Захиалагч байгууллага:	Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар

1.Ажлын даалгавар өгөх үндэслэл:	- Дорноговь аймгийн 2025 жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2025 оны төсөв батлах тухай аймгийн ИТХ тогтоол, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний 1.1.7 дахь заалт
2.Ажлын зорилго, гарах үр дүн:	Ханги хилийн боомтын хүн амыг усны найдвартай, баталгаат шинэ эх үүсвэрээр хангах: - Улс, орон нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан хүн амыг ус хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар эрэл-хайгуулын ажлыг гүйцэтгэж, унд ахуйн усны чанар найрлагад нийцсэн усны нөөцийг тогтоох - Ханги хилийн боомтын ус хангамжийн хэрэгцээг хангаж чадахуйц газрын доорх усны эх үүсвэрийг илрүүлэн тогтоож, ашиглах боломжит нөөцийг үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлж тодорхойлон олборлолтод бэлтгэсэн байна - Хүн амын унд ахуйн ус хангамжийн зориулалттай гидрогеологийн эрэл-хайгуулын ажлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа арга зүй, аргачлалын дагуу явуулж, Ханги хилийн боомтын ус хангамжийн хэтийн төлөвлөлтийн шаардлагад нийцүүлнэ - Усны чанар найрлага нь хүн амын унд, ахуйн ус хангамжид ашиглах боломжтой эсэхэд дүгнэлт гаргасан байна.

	- Хүн амын ундны усны чанарын MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан газрын доорх усны эх үүсвэрийг тогтоосон талбайд ус хангамжийн зориулалттайгаар ашиглах инженерийн хийцтэй 1 цооног, мониторинг буюу хяналт шинжилгээний 1 цооногийг технологийн дагуу өрөмдөж, ундны усанд тохирсон зэвэрдэггүй ган шүүрийн яндангаар тоноглон, ашиглалтад бэлтгэсэн байна. - Ирээдүйн ус авах байгууламжийн бүдүүвчийг оновчтой хувилбараар сонгож, түүний ашиглалтын үйл ажиллагааны горимын талаар мэргэжлийн заавар зөвлөмж өгсөн байна - Ундны усны ус хангамжийн эх үүсвэрийг хомсдох, бохирдохоос хамгаалах санал, зөвлөмж боловсруулах, усны сан бүхий газар, усны эх үүсвэрт энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн заагийг мэргэжлийн байгууллага тогтоосон байна - Унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоосон зураг хийж, дэглэмийг мөрдүүлэх талаарх зөвлөмж гаргаж, усаар хангагч байгууллага болон сав газрын захиргаанд хүлээлгэн өгсөн байна - Газрын доорх усны ордын тэжээгдлийн мужийн хил заагийг тодорхойлсон зураг гаргасан байна
3.Судалгааны ажлын хөтөлбөр:	Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын хүрээнд зайлшгүй болон нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлууд: - Геологи-гидрогеологийн талбайн маршрут, ажиглалт, уст цэгийн бүртгэл, тооллого - Талбайн геофизик, цооногийн каротажийн хэмжилт судалгаа - Гидрогеологийн өрөмдлөг - Шавхалт, туршилтын ажлууд - Гидрохимийн дээжлэлт - Горимын ажиглалт - Лабораторийн шинжилгээ - Топо-геодезийн холболтын ажил - Суурин боловсруулалт - Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх
4.Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:	**<u>Хээрийн ажлын бэлтгэл:</u>** - Газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг явуулах төсөл, төсөв зохиох, техник хэрэгсэл, хүн хүчийг бэлтгэх - Тухайн бүс нутгийн хэмжээнд өмнө хийгдсэн ижил төстэй геологи-гидрогеологийн судалгааны материалтай нэг бүрчлэн танилцаж, зохих боловсруулалт хийж, цаашид явуулах судалгааны ажлын аргазүй аргачлалыг нарийвчлан боловсруулах - Ханги хилийн боомтын усан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэхийн тулд өмнө хийгдсэн судалгааны ажлын мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, агаар сансрын зураг ашиглан хэрэглэгчдэд хамгийн ойр, усны өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах газрын доорх усны хуримтлал бүхий талбайг сонгож дүн шинжилгээ хийх **<u>Хээрийн судалгааны үе:</u>** - Эрэл-хайгуулын судалгааны дэвсгэр талбайн хүрээнд геологи-гидрогеологийн маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийг явуулж, геоморфологи, структур-тектоникийн байдал геологийн тогтоц, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй газар дээр нь нарийвчлан танилцах - Газрын гадаргуугийн орчин үеийн хотгор, гүдгэрийн дүрс зүйн холбогдох хэмжилт, шаардлагатай бичиглэл,баримтжуулалтыг хийх - Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглуулан, агаар сансрын зурагт тайлал, боловсруулалтыг хийж гидрогеологийн эрлийн

	шалгуур, шинж тэмдгийг илрүүлэн цаашдын судалгаандаа ашиглах - Геофизикийн талбайн судалгааг зохих арга аргачлалын дагуу явуулж, газрын доорх усны байгалийн нөөцийн хуримтлал, бөөгнөрөл байж болох тодорхой цэг, усжсан бүсийг тогтоох - Судалгааны талбайн геологийн тогтоц, гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн үнэлж, ус хэрэглэгчид хамгийн ойр байх өндөр усжилттай, газрын доорх хуримтлал бүхий талбайг сонгон шинээр өрөмдөх цооногуудын байршлаг төлөвлөх - Шавхалтын ажлыг түвшний бууралт, сэргэлтийн хэмжилтийн өгөгдлүүдийг автомат болон цахилгаан түвшин хэмжигч багажаар хэмжих - Гидрогеологийн өрөмдлөг, шавхалт болон гидрохимийн дээжлэлтийн ажлыг зохих арга зүй, аргачлалын дагуу гүйцэтгэж, гарсан үр дүн онолын тайлал, боловсруулалтыг хийх - Эрэл-хайгуулын гидрогеологийн судалгаа явуулж буй талбайд тархсан газрын доорх уснаас гидрохимийн сорьц авч химийн дэлгэрэнгүй болон бичил элементийн шинжилгээг MNS 0900:2018 стандартад харьцуулан хийлгэж, үр дүнг харьцуулах, чанар, химийн найрлагад мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх - Хайгуулын ажлын үр дүнд тогтоосон өндөр усжилттай цооногоос сонгон ашиглалтад бэлтгэх - Усан хангамж болон хяналт шинжилгээний зориулалттайгаар ашиглах инженерийн хийцтэй цооногийг технологийн дагуу өрөмдөх, тоноглох - Цооногийн хана, суултын яндангийн хоорондох хоосон орон зайд 5 мм-ийн сайн мөлгөржсөн хайрган шүүр хийх, дээд дөрөвдөгчийн уст үеийг хаах зорилгоор бентенитон түгжээ хийж, түүнээс дээших хоосон орон зайд цементэн бэхэлгээ хийх - Усны эх үүсвэр болгон ашиглах цооногоос бактерлогийн сорьц авч MNS 0900:2018 стандартад харьцуулан дүгнэлт өгөх - Гидрогеологийн өрөмдлөг, шавхалт-туршилт хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийг хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, акт үйлдэх - Хээрийн ажлын үед өрөмдлөгийн журнал болон шавхалт туршилтын ажлын анхдагч хээрийн материалуудыг Усны нөөцийн хэлтэст хүлээлгэн өгөх **<u>Суурин боловсруулалтын үе:</u>** - Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг БОНХАЖС-ын 2015 оны А-173 дугаар тушаалаар батлагдсан “Газрын доорх усны нөөцийг хүлээн авах ангилал, зэрэглэл”-ийн аргачилсан зааврын дагуу боловсруулж, Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах
5. Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн орчин	- Усны тухай хууль - БОНХАЖСайдын 2015 оны А-173 дугаар тушаалаар баталсан Усны эрэл-хайгуул хийх ажлын аргачлалыг мөрдөж ажиллах
6.Тавигдах шаардлага, тусгай нөхцөл:	- Хээрийн ажлын явц, гүйцэтгэл, арга аргачлалыг хянах зорилгоор 1 удаа хөндлөнгийн хяналт хийх зардлыг гүйцэтгэгч хариуцна - Дорноговь аймгийн Байгаль орчны газар, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа сум орон нутагт ажлаа танилцуулан, тайлагнаж хамтран ажиллана

7.Үр дүнг тайлагнах	- Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг БОНХАЖСайдын 2015 оны А-173 дугаар тушаалаар батлагдсан “Газрын доорх усны нөөцийг хүлээн авах ангилал, зэрэглэл”-ийн аргачилсан зааврын дагуу боловсруулж, Усны нөөцийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тайланг Усны газрын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУУЛАЛТ, БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.МӨНХ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
ГАЛБА ӨӨШ ДОЛООДЫН ГОВИЙН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ УСНЫ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ, ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХЙУН
УС АШИГЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Э.ЖАНЧИВДОРЖ